



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/111

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Худалдааны гудамж-1-115)-тоотод байршилтай "Говийн чонос" ХХК (2012715)-ын үйлчилгээний зориулалттай 1250 м.кв (0,1га) газрыг Чулуунбаатар овогтой Сэргэлэнбаатар (ЗФ:89051531)-т зориулалтаар нь шилжүүлж 16 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 185 дугаар захирамжийн "Говийн чонос" ХХК-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000303408 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010328